



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/93

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Замын сангийн хөрөнгө оруулалтаар “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд 1 болон 2 дугаар сард зарцуулах зардалд 9 450 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 9 450 000 төгрөг /есөн сая дөрвөн зуун тавин мянга/-ийг аймгийн Замын сангийн 4.9-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/93 Ch

02 00415

Аймгийн Засаг даргын 2020 оны
02 дугаар сарын 13-ны өдрийн
А/93 дугаар захирамжийн хавсралт

“ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГТ ХОГ ОТВОЛДОЖ ДАРЖ ЗАМ
ГАРГАХ АЖИЛ”-ЫН ХҮРЭЭНД ЗАРЦУУЛАХ ЗАРДАЛ

| Д/д | Зардлын төрөл | Хэмжих нэгж | Тоо хэмжээ /60 хоног/ | Нэгж үнэ /төгрөг/ | Нийт үнэ /төгрөг/ |
|-----|--------------------------------------|-------------|-----------------------|-------------------|-------------------|
| 1. | Хогийн цэгт ажиллах шатахууны зардал | л | 3000 | 2450 | 7 350 000 |
| 2. | Тос, масло, сэлбэг | багц | 60 | 10000 | 600 000 |
| 3. | Хөдөлмөр хамгааллын зардал | Хүн/өдөр | 60 | 10000 | 600 000 |
| 4. | Жолоочид урамшуулал, хоолны зардал | Хүн/өдөр | 60 | 15000 | 900 000 |
| | Нийт | | | | 9 450 000 |

-oOo-